




МОНГОЛ ӨРХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛИЙН
МӨРИЙН 
ХӨТӨЛБӨР

2020

Үндэсний бодлогын хорооны
2020 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн
11/07 дугаар тогтоолын хавсралт



УИХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРӨЛЦӨХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд сууринласан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Монгол хүн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны УИХ-ЫН СОНГУУЛЬД “ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО” мөрийн хөтөлбөрөө ТА БҮХЭНДЭЭ ТОЛИЛУУЛЖ БАЙНА.

ГАРЧИГ



НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ	4
1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол.....	4
1.2. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ	5
1.3. Хүн амын хөгжил.....	7
Хүн амын өсөлт	
Өрх гэр бүл.....	8
Ажлын байр хөдөлмөр эрхлэлт.....	8
Нийгмийн хамгаалал.....	9
1.4. Соёл, урлаг, спорт	9
ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ	11
2.1. Хямралын үеийн онцгой бодлого.....	11
2.2. Өсөлтийн бодлого.....	13
Жижиг дунд бизнес.....	14
Бизнесийн дархлаа	15
Сангийн бодлого	15
Татварын бодлого	16
Мөнгөний бодлого	17
Санхүүгийн зах зээл.....	17
Баялгийн удирдлага.....	18
Хөдөлмөрийн зах зээл.....	18
2.3. Төрөлжилтийн бодлого.....	19
Аж үйлдвэрлэлийн салбар	20
Эрдэс баялгийн салбар.....	21
Дэд бүтэц	22
Эрчим хүч	24
Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа холбоо.....	25
Барилгын салбар	26
Аялал жуулчлал.....	26
Хүнсний үйлдвэрлэл	27
Хөнгөн үйлдвэрлэл.....	28
Бүтээлч үйлдвэрлэл.....	29
ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ.....	30
3.1. Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил.....	30
Бүсчилсэн хөгжил	30

2

3.2. Орон нутгийн хөгжил.....	30
“Шинэ хөдөө” хөтөлбөр	31
Иргэдийн оролцоотой “Шинэ сүм” төсөл.....	31
“Чинээлэг малчин” хөтөлбөр.....	32
3.3 Бэлчээр ашиглалт	32
3.4. Мал аж ахуй.....	32
3.5. Газар тариалан.....	32
3.6. Нийслэл хот, хотуудын хөгжил	34
Нийслэл Улаанбаатар хот	34
Дагуул ба шинэ хот.....	35
ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ.....	36
4.1. Иргэнээ хамгаалдаг хууль	36
4.2. Иргэндээ үйлчилдэг засаглал	38
4.3. Иргэн нь шийддэг нийгэм	39
4.4. Хөгжлийг дэмждэг хууль	40
ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ.....	41
5.1. Үндэсний аюулгүй байдал	41
5.2. Гадаад бодлого	42
5.3. Батлан хамгаалах бодлого.....	42
5.4. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил	43
Экосистемийн тэнцвэртэй байдал.....	43
Байгаль орчны тогтвортой хөгжил.....	44

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ



1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Монгол эх орныхоо байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн хамгааллын бодлогыг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

- Аж үйлдвэрлэл 4.0, технологийн хувьсгал, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухааны эрин үед өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээл, шинэ төрлийн ажлын байрны шаардлагыг хангах хөрвөх чадвар, өндөр мэдлэг бүхий мэргэжилтэн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, сургах бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, бүх түвшний сургуулиудад олгож байгаа боловсролын агуулга, хөтөлбөр, арга хэлбэрийг шинэчилнэ.
- Боловсролын салбарын дэлхийд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, 20 байраар урагшлуулна.
- Боловсролын салбарын төрийн өмчит их, дээд сургуулиудын менежментийн тогтолцоог өөрчилж, судалгааны лабораториудын техник хэрэгсэл, технологийг шинэчилж, бизнесийн салбарын өсөлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, инновацыг дэмжихэд шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа, туршилтыг чиглүүлж, хөгжүүлнэ.
- Хот болон хөдөө орон нутаг, төр болон хувийн өмчит сургуульд суралцагсдын дундаж онооны зөрүү 50-182 байгааг үе шаттай бууруулах “Боловсролын чанарын ялгааг арилгах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг сэргээн сайжруулж, үргэлжлүүлнэ.
- Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Бүх оюутныг сургалтын зээл авах тэгш боломжоор хангана.
- Гадаад орны их, дээд сургуульд 10,000 оюутныг /ялангуяа дэлхийн шилдэг 100 их дээд сургуульд/ суралцах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон эх орондоо эргэн ирж буй залуучуудад зориулж “XXI зууны диаспора” хөтөлбөрийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.



- Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.
- Оюутан сурагчдыг сургалтын гэнэтийн өсөлтөөс хамгаалах эрхзүйн боломжийг бүрдүүлнэ.
- Амжилттай хэрэгжиж буй “Мянган инженер” хөтөлбөрийг “Түмэн инженер” хөтөлбөр болгон үргэлжлүүлнэ.
- Багш нарын хөдөлмөрийн бүтээмжийг бодитойгоор үнэлж, цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг улсын дунджид хүргэх, улмаар мөнгө, төсвийн бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын чадавхыг бэхжүүлэх, багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад улсын төсвийн санхүүжилтийг түлхүү чиглүүлнэ. “Шинэ багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд аймаг, дүүргийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг байх эрхзүйн орчныг бүрдүүлнэ.
- Эцэг, эх, асран хамгаалагчид багшаа сонгох боломжийг олгож, хувьсах зардлыг санхүүжүүлэх тогтолцоонд шинэчлэл хийнэ.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, бассейн, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг шинэчлэн тогтоож, мөрдүүлнэ. Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам, шат бүхий хэрэгсэл суулгана.
- Англи хэлийг боловсролын хоёр дахь хэлний түвшинд хүргэж, бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулна.
- Нээлттэй эх бүхий зайны сургалтыг хөгжүүлнэ. Зайны цахим сургалтаар ерөнхий болон дээд боловсрол эзэмших боломжийг хуульчилж, хэрэгжүүлнэ.
- Их сургууль түшиглэсэн судалгааны төв, лабораториудыг нэмэгдүүлж, олон улсын шинжлэх ухааны паркийг байгуулна.
- Хүн ам, албан хаагч, ажилчдын цахим боловсролыг дээшлүүлж, бүх нийтийн цахим боловсролыг (Digital Literacy) 80%-д хүргэнэ. Боловсролын тогтолцоонд цахим боловсролын ур чадвар суулгах хөтөлбөрийг тусгана.

1.2. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ

Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн эрсдэлд орохгүй байхаар эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд реформ хийнэ.

Салбарын хүний нөөцийн сургалт, чанар хүртээмж, төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ. Эрүүл мэндийн салбарт технологийн хувьсгал хийх замаар эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй болгож, ил тод, авлигагүй, сайн засаглалтай, гүйцэтгэлээр урамшуулдаг, чөлөөт өрсөлдөөнтэй болгож шинэчилнэ.

Салбарын санхүүжилтийн гажуудлыг засаж, үрэлгэн зардлыг багасгаж, судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг дэмжиж, монголын уламжлалт анааах ухааны хөгжлийг эрчимжүүлнэ.

- Хорт хавдрын шалтгаант нас барагтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг Азийн орнуудын түвшинд хүргэнэ.
- Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний иж бүрэн тоног төхөөрөмж бүхий төвийг Улаанбаатар хотод, оношилгооны төв, хавдрын хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх төвийг нийслэл, аймгуудад барьж, байгуулна.
- Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн шинэ тогтолцоонд шилжинэ.
- Амиа хорлолтын шалтгаан сэтгэл гутралын өвчлөл, хар тамхи, мансуурах бодист донтох, хамаарлын болон бусад сэтгэцийн эмгэг өвчнийг эрт илрүүлж, эмчлэх, нөхөн сэргээх төвийг байгуулна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын агуултыг олон улсын стандартад нийцүүлнэ.
- 1000 сувилагч сургаж бэлтгэнэ. Сувилагч бэлтгэдэг их дээд сургуулийг бодлогоор дэмжинэ.
- Эмч, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн бүтээмжийг бодитойгоор үнэлж, цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг улсын дунджид хүргэх, улмаар мөнгө, төсвийн бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн залуу эмч нарын мэргэжил, боловсролыг хуулийн дагуу 5 жил тутамд тасралтгүй дээшлүүлнэ.
- Сонгон шалгаруулалтад тэнцсэн ерөнхий мэргэжлийн бакалаврын зэрэгтэй эмч нарыг резидентын сургалтад хамруулж, мэргэжлийн цол, зэрэг, ур чадвараас хамаарсан нэмэгдэл олгох тогтолцоог бүрдүүлнэ.
- Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
- Эмчийн чадавх, эмчилгээний үр дүнг үнэлэх цахим систем ажиллуулж, сайн эмчийг сонгож үйлчлүүлэх өрсөлдөөнд суурилсан тусlamж үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Монгол хүний дундаж наслалтыг 75-д хүргэнэ.
- Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний санхүүжилт, даатгал, эрх зүйн орчны тогтолцоог шинэчилнэ.
- Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.

- Олон улсын даатгалын сүлжээнд нэгдэж, хувийн болон давхар даатгалд нэгдэх тогтолцоог бүрдүүлнэ.
- Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг олон улсын стандартад ойртуулна.
- Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх бөгөөд эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлнэ.
- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг хүн амын шилжилт хөдөлгөөнтэй уялдуулна. Нэг иргэнд ногдох тусламж үйлчилгээний зардлын хэмжээг жил бүр шинэчлэн тогтоо зарчимд шилжинэ.
- “Био аюулгүйн гуравдугаар зэрэглэлийн лаборатори”-ийг ашиглалтад оруулж, цар тахал, шинэ вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх нөхцөлийг яаралтай бүрдүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт орчин үеийн хиймэл оюун ухаан, хүний бүтэн генийг тайлж унших технологи, био-протез, робот мэс заслын систем болон бусад дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх шаталсан бодлого хэрэгжүүлнэ.
- Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд төрөөс бодлогоор дэмжинэ.
- Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, тарималжуулж, үржүүлнэ. Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжинэ.
- Эм, хүнсний хяналтын асуудал хариуцсан агентлагийг Засгийн газрын бүтцэд шинээр бий болгоно. Эм, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд стандарт тогтооно.

1.3. Хүн амын хөгжил

Хүн амын өсөлт

- Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хүүхдээ асран хамгаалж байгаа гурав хүртэлх насын хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдээ өсгөсөн жилийн үнэлэмжийг шинэчлэн тогтооно.
- Нийгмийн хамгааллын хүрээнд олгодог тэтгэмжийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан индексжүүлж нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн мөнгийг хүн амыг өсгөх бодлого гэж үзэн хүүхэд бүрд ялгаварлалгүйгээр олгодог бодлогоо сэргээнэ.
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насын хүүхдийг хүмүүжүүлэх бодлогыг шинэчилж, хүүхдийг гэр



бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж, төлөвшиг хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.

- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг сэргээж, хэрэгжүүлнэ.

Өрх гэр бүл

- Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т "...газрын хэвлэлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ." гэсний дагуу өрхийн бизнес, санхүүг дэмжсэн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Хамтын тэтгэврийн тухай хуулийг сэргээж, мөрдөнө.
- Ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулна.
- Хот, хөдөөгийн иргэдээ зээлийн хөнгөлттэй нөхцлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн 100 мянган өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
- Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжих зорилгоор "Гэр бүлийн өдөр"-ийг бий болгож, гэр бүл – нөхөн үржихүйн боловсролд онцгой ач холбогдол өгнө.
- Өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөл бүхий тэтгэлэг олгох тогтолцоо, богиносгосон ажлын цагийн хуваарийг эдлэх боломжийг бүрдүүлнэ.
- Хот байгуулалт, барилга, нийгэм, соёлын байгууламжийн төлөвлөлтөд нийт иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийг бий болгоно.
- Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгavarлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санаачилга, манлайллыг дэмжинэ.
- Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Ажлын байр хөдөлмөр эрхлэлт

- Ажлын цагийн уян хатан зохицуулалт, зайнаас болон цахим орчинд хөдөлмөрлөх боломж бүхий ажлын байрны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.


- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалтай уялдуулна.
- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, ажилгүйдлийг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн сангийн орлогыг олон эх үүсвэрээс бүрдүүлж, ажилгүйдлийн даатгалыг өргөтгөн хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тогтолцоо болгон хөгжүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.
- Гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.
- Хилийн чанадад ажиллаж, амьдарч буй иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор улс орнуудтай нийгмийн хамгааллын талаар хамтран ажиллана.

Нийгмийн хамгаалал

- Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ. Хавтгайсан халамжаас татгалзаж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлнэ.
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлнэ.
- Асрамжийн үйлчилгээг төрөлжүүлж, хувьсах зардлыг нэмэгдүүлнэ.
- Ахмадын өдөр өнжүүлэх төвүүдийг бий болгож хөгжүүлнэ.
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, хэлбэр, стандартыг бий болгон мөрдүүлнэ.
- Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогоор тодорхойлсон олон давхрагат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлж, тэтгэвэр авагчдын орлогыг эрс нэмэгдүүлнэ.
- Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангаж, мэдээлэл, тайланг ил тод болгож, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

1.4. Соёл, урлаг, спорт

- Уламжлалт өв соёлоо төрийн бодлогоор дэмжин, боловсролын хөтөлбөрт тусгаж, Монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.
- Соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгоно.



- Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Үндэсний агуулга бүхий кино, тайз, дэлгэцийн бүтээлийг хөгжүүлж, дэмжинэ.
- Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчилж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагчтай байх тогтолцоог бий болгоно.
- Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудын бие даасан байдал, санхүүгийн эрх чөлөөг нэмэгдүүлнэ.
- Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэн эдийн засгийн бодит салбар болгон хөгжүүлнэ.
- Соёл урлагийн зах зээлд зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах чиглэлд шийдвэртэй арга хэмжээнүүдийг авна.
- Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд гаргахад дэмжинэ.
- Мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага төгсөгч, дадлагажигчдад эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Тайз, дэлгэцийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж, түүх, соёлын агуулга бүхий контентыг үзэгчдэд хүргэх олон платформт хөтөлбөрийг нэвтрүүлнэ.
- Биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлнэ.
- Спорт цогцолбор, бассейн, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх багтаамж ихтэй байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний хэмжээний тэмцээнүүдийг зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар олон нийтэд ойлголт өгөх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.
- Их спортыг дэмжин, спорт клубийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ



2.1. Хямралын үеийн онцгой бодлого

Дэлхийн нийтийг хамарсан (КОВИД-19) цар тахлын тархалтаас шалтгаалж олон улсад эдийн засгийн түүхэнд байгаагүй маш ноцтой байдал үүсээд байна. Дэлхийн эдийн засаг 2020-2021 онд уналтад орох төлөвийг олон улсын байгууллагуудаас 3 дугаар сарын байдлаар гаргасан байна. Монгол Улсын эдийн засгийн гол бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ мөн уналтад ороод байна. Монгол Улсад 2020 оны эхнээс авч хэрэгжүүлсэн урт хугацааны гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлаас шалтгаалж худалдаа эрхлэгчид болон үйлдвэр үйлчилгээний салбарт бизнес эрхлэгчдийн орлого их хэмжээгээр тасалдаад байна. Үүнээс үүдэж арилжааны банкнуудаас авсан зээлийн эргэлт төлөлт буурснаас цаашид чанаргүй зээлийн хувь хэмжээ өсөх хандлагатай байна. Энэхүү үйл явц банкнуудын үйл ажиллагаанд нөлөөлж, санхүүгийн системд савлагаа үүсгэнээр эдийн засаг бүхэлдээ доголдох ноцтой эрсдэлтэй тулгараад байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй төсвийн үрэлгэн зарцуулалтаас шалтгаалж Засгийн газрын өр нэмэгдсээр байна. Тухайлбал 2020 оны улсын төсөв хасах 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай батлагдсан бөгөөд эрдэс баялгийн үнийн уналт, компаниудын үйл ажиллагааны доголдлоос үүдэж компаниуд татвараа төлөх боломжгүй байдал үүссэн. Ингэснээр улсын төсвийн татварын орлого тасалдаж, цаашид төсвийн алдагдал нэмэгдэх нөхцөл байдал үүсэх юм. Олон Улсын банк санхүүгийн байгууллагуудаас ач холбогдол өндөртэй зардлуудыг эрэмбэлэх, үрэлгэн, ач холбогдол багатай зардлуудыг тэвчихийг тогтмол зөвлөж байна. Тухайлбал ОУВС-ын тэргүүн Их долоогийн удирдагч нартай уулзсан уулзалтын өмнө гаргасан мэдэгдэлдээ төсвийн хатуу бөгөөд нягт уялдаа холбоотой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хохирлыг багасгах боломжтой ба улс орнууд төсөв-санхүүгийн эрчимжүүлсэн арга хэмжээ авах нь цаг тутам чухал болж байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улсын нийт гадаад өр 2016 онтой харьцуулахад 35%-өөр өсөж 22.7 тэрбум ам доллароос 30.6 тэрбум ам. доллар хүртэл өссөн байна. Энэ нь Монгол Улсын гадаад валютын улсын албан нөөцөөс даруй 7 дахин их үзүүллэлт юм.¹ Үүн дотор Засгийн газрын өр сүүлийн 4 жилд 4.8 тэрбум доллароос 7.7 тэрбум долларт хүрчээ. Цар тахлаас үүдсэн эдийн засгийн бууралт нь дэлхийн зах зээл эрдэс баялгийн үнэд² шууд нөлөө үзүүлсэн. Энэ

¹ Гадаад валютын албан нөөц 4,362 сая ам.доллар (2020 оны 1-р сарын байдлаар)

² Оны эхэнд тонн нэг тус бүр нь 6,165 ам долларийн байсан Зэсийн ханш 22%-аар унаж өнөөдрийн ханшаар 4,854 ам долларын хүрээд байна. Бусад эрдэс баялгийн үнэ 20-25%-аар тус тус уналттай байна.

нь манай улсын экспортын орлогыг бууруулснаар зах зээл дээрх валютын ханшин дээр шууд савлагаа үүсгэх эрсдэлтэй юм. Энэхүү үйл явц нь цаашид даамжирсаар дээр дурдсан гадаад өр, төлбөрийг төлөхөд хүндрэл учруулж, эдийн засгийн дефолтод хүргэх аюулыг бий болгоод байна.

Иймд ажлын байрыг хадгалах, эдийн засгийг эрчимжүүлэх, хөтөлбөрийг нэн даруй боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Ажлын байрыг хадгалж, иргэн, бизнесээ дэмжсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нэг ч иргэнээ орлогоор тасалдуулж, ажлаас халуулахгүй, орон байрнаас нь салгахгүй байх бодлого баримтална. Нэг ч компанияи дампууруулахгүй, ялгаварлахгүй байх арга хэмжээ авч, хүнд суртлыг устгана. Цар тахалтай тэмцэх онцгой хөтөлбөр, багц хуулиудыг шинэ УИХ-ын анхдугаар хуралдаанаар гишүүд тангаргаа өргөнгүүт батална.

Онцгой хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын 2020 оны төсвийн зардлыг ач холбогдоор нь эрэмбэлж, төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж, уг хэмнэгдэж буй зардлуудыг иргэн, компаниудад хүндрэлийг давах зээл олгох зорилгоор банкнуудад нэмэлт санхүүжилт өгөх буюу эдийн засгийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. 2021 онд нэмэлт төсвийн эх үүсвэрийг бий болгоно.


- Төсвийн хэмнэгдсэн зардлыг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ажлын байрыг хадгалсан болон нэмэгдүүлсэн аж ахуй нэгжийг дэмжин зарцуулж, аж ахуй нэгж байгууллагуудын цалингийн санд Засгийн газраас шууд дэмжлэг үзүүлнэ.
- Малчдын зээлийн хүү, төлбөрийг хойшлуулна. Шинэ зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Эдийн засгийн хүндрэлийн үед буюу 2020-2021 онд иргэн, бизнес эрхлэгчийн татвар, хураамжийн дарамтыг бууруулна.
- НӨАТ-ын хувийг 5% болгож бууруулна. Гаалийн болон бусад татвар хураамжийн төлбөрийг тухайн иргэн, бизнес эрхлэгчид дарамтгүйгээр шийдвэрлэнэ.
- 2016-2020 онд шинээр бий болгосон болон хувь хэмжээг нэмэгдүүлсэн бүх төрлийн татвар, хураамжийг өмнө нь дагаж мөрдөж байсан хувь хэмжээнд хүртэл бууруулах арга хэмжээг авна.
- Иргэн, аж ахуйн нэгжийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргээс чөлөөлнө. Аж ахуй нэгжийн татвартай холбогдон битүүмжилсэн дансыг нэн даруй нээж, түгжигдсэн мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулна. Бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг хязгаарласан мэргэжлийн хяналт, болон бусад

төрийн байгууллагын тогтоол шийдвэрийг хуулиар зохицуулан түдгэлзүүлнэ.

- Эдийн засгийн онцгой нөхцөл байдлын үед татварын өр үүсгэсэн аж ахуй нэгжүүдэд татварын алданги, хүү, торгууль ногдуулахыг хориглоно. Мөн орон сууцны ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн төлбөрийг Татварын ерөнхий хууль, Гамшигаас хамгаалах тухай хуулийн дагуу уян хатан шийдвэрлэнэ.
- Төрийн албан хаагчдын цалинг 2021 оны 6 дугаар сар дуустал баталгаажуулах, ажлын байрны хөдөлгөөн, халагдахыг хязгаарлана. Онцгой нөхцөлд онцгой дэглэмээр ажилласан төрийн бүх албан хаагчдад санхүүгийн урамшууллыг Төрийн албаны тухай хууль, Гамшигаас хамгаалах тухай хуулийн хүрээнд 2020 онд багтаан шийдвэрлэнэ.
- 2021-2022 онд төлөх Засгийн газрын гадаад, дотоод зээл, бондын төлбөрүүдийг макро эдийн засгийн тогтвортой байдалд нийцүүлэн төлж барагдуулах эсхүл дахин санхүүжүүлнэ. Хөгжлийн банк болон Төрийн банкаар дамжуулан хямралын дараах сэргэлтийн хөтөлбөрүүдийн санхүүжилтийг бий болгоно.
- Хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимтэй үргэлжлүүлнэ. Засгийн газраас шаардлагатай шийдвэр, зөвшөөрөл, хөнгөлөлтүүдийг нэн даруй олгоно. Үүнд: авто зам, төмөр зам, эрчим хүч, уул уурхай, боловсруулах үйлдвэр, Оюу толгойн гүний уурхай, газрын тос боловсруулах үйлдвэрийн гэх мэт төслүүд багтана. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, санхүүжилт нь боссон, богино хугацаанд үр ашиг авчрах төслүүдийг хэрэгжилтийг эрчимжүүлнэ. Геологи хайгуулын ажил эхлэхэд тулгарч буй асуудлыг нэг мөр шийдэж, геологи, хайгуулын ажлуудыг шууд эхлүүлнэ. Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх талаар эрс шинэчлэлт хийнэ.
- Олон улс дахь эдийн засгийн уналтаас шалтгаалан хөрөнгө оруулалтын өгөөж буурч буй энэ нөхцөлд Монгол Улсад өгөөж өгөх хөрөнгө оруулалтын төслүүдэд татварын тогтвормжуулалтыг олгож, шинэ ажлын байрыг яаралтай бий болгоно.

2.2. Өсөлтийн бодлого

- 2030 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 10,000 ам.доллар, монгол хүний бодит орлогыг дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээ (нэг хүнд ногдох ДНБ-ний 10 хувь)-д хүргэж, нийт эдийн засгийг 40 тэрбум ам.долларт хүргэх бодлогыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ. Нийт экспортын хэмжээг 30 тэрбум ам.долларт, түүний дотор уул уурхайн бус салбарын экспортыг 30 хувьд хүргэнэ. 2020-2024 оны хувьд дээрх зорилтыг хангах нөхцөлийг биелүүлэх бөгөөд 2030 онд хүрэх зорилтын 40 хувийг биелүүлсэн байна.



- Эдийн засгийн бүтцийн шинэчлэлт хийнэ. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн, эрчимжүүлнэ. Засаглалын зөв механизмыг бүрдүүлж, мөчлөг дагасан сонгуулийн бодлогоос татгалзаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангруулж, улс төрчдийн ашиг хонжоо харсан түншлэлд суурилсан эрх мэдлийн төлөөх өрсөлдөөнийг устгана.
- Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон хот, хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.
- Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн зуун мянган шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
- Эдийн засгийн өсөлтийг хангах том төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. Ган, зэс, нүүрс-хими, нефтийн гэсэн дөрвөн чиглэлийн суурь аж үйлдвэрүүдийг тухайн бүс, аймгийн онцлог, байгалийн нөөцд тулгуурлан үе шаттайгаар байгуулна.

Жижиг дунд бизнес

- Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гарааны бизнесийг гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн Big Data үүсгэж, шинэ санаачилгыг хэрэгжүүлэх боломж бүхий нэгдсэн платформыг бий болгон аюулгүй байдлыг хангана. Уламжлалт үйлдвэрүүдтэй холбох “Интернет плас SMEs” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнесийн эрхлэлтийн хөрөнгө оруулалтын анхны санхүүжилтийг ЖДҮ-ийн сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.
- Жижиг үйлдвэрлэлийг технологийн шийдлээр дэмжихэд төрөөс анхаарч, хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.
- Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гарааны бизнесийн гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн “Биг дата” үүсгэж, нэгдсэн платформ бий болгон аюулгүй байдлыг хангана. Уламжлалт үйлдвэрлэлтэй холбох Интернет плас SMEs хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.

Бизнесийн дархлаа




- Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуйн нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг тогтолцоог бий болгоно. Тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлнэ.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг өөрчлөн байгуулж, чиг үүргийг нь тухайн салбарт стандарт нэвтрүүлэх, хангуулах, олон нийтийн оролцоо бүхий байгууллагуудад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшилд зөвлөгөө өгдөг, үйлчилдэг, дэмждэг болгоно.
- Бизнест учирдаг авлигын дарамтыг арилгах чиглэлд хүчтэй ажиллана. Технологийн дэвшлийг ашиглах замаар авлигыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник, аж үйлдвэрийн IV, Инновацын 2.0 эрин үеийн технологийн дэвшлийг бүх шатанд ашиглах боломжийг дэмжиж, дижитал шилжилтийг хурдасгана.
- Инновацыг дэмжин үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ажиллах их дээд сургууль, судалгааны төвүүдийг дэмжих Дижитал санг үүсгэн байгуулна.
- Бүртгэл, гааль, татвар, хяналт, шалган нэвтрүүлэх, лавлагаа, мэдээлэл, худалдан авах ажиллагаа зэрэг төрөөс авах бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. Гадаад худалдаа, гаалийн бүрдүүлэлтийн хялбаршуулсан “нэг цонхны систем”-ийг бий болгож, авлигаас ангид, хувь хүний үйлдлээс үл хамаарсан, цахим системийг хэрэгжүүлж, гадаад худалдааны урсгалыг сайжруулна.
- Өмчийг эрхийг баталгаажуулж, хувийн өмчийг хамгаалах чиглэлд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалтын сан, хамтын хөрөнгө оруулалтын санг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Илүү өндөр үнэлэмж бүхий аж үйлдвэрүүд болон зайнаас ажиллах цагийн ажлын байранд ажиллах ажиллагсдыг бэлтгэх боловсролын тогтолцоонд онцгой анхаарч бүтэээмжийг нэмэгдүүлнэ.
- Эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад худалдааг олон тулгууртай болгоно.
- Худалдааны хууль баталж, худалдаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаална.
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжинэ.

Сангийн бодлого

- Төсвийн орлогыг уул уурхайн бүтээгдэхүүний үнийг өсөлтөөс хэт хамааралтай байгаа одоогийн байдлыг өөрчилж, төсвийн орлого, зарлагын шинэчлэл (реформ) хийнэ. Улсын төсвийн орлогод АМНАТ-ын орлогын

A handwritten signature in blue ink.

A handwritten signature in black ink.



оруулж тооцохгүй бөгөөд зөвхөн таван хувийг уул уурхайн бус салбарыг дэмжих зорилгоор төсөвт төвлөрүүлнэ.


- Улсын нэгдсэн төсвийг алдагдалгүй баталж, улсын өрийн өсөлтийг хязгаарласан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг тууштай хэрэгжүүлнэ.
- Түүхий эдийн үнийн уналт, өсөлтийн мөчлөгт өртөмтгий нөхцөлд мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, тогтвортой байдлыг зөвлрүүлж ажиллана. Төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхгүйгээр урт хугацааны хөгжлийг дэмжсэн хөтөлбөрөөр өрийн удирдлагын хэрэгжүүлэх оновчтой бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- Төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- Төсвийг судалгаанд суурилсан төлөвлөлт, сахилга, хэрэгжилт, хяналтыг хангах оновчтой систем бүрдүүлнэ. Судалгааны тинк танк ажиллуулна.
- Макро эдийн засгийн уялдааг хангахад чиглэсэн оновчтой бүтэц бий болгоно.

Татварын бодлого

- Татварын шинэчлэлийн бодлогыг гагцхүү Сангийн яамны хүслээр биш, татвар төлдөг бүх иргэд, аж ахуй нэгжийн оролцоотой хэрэгжүүлж, бизнес эрхлэгчид, бүх иргэдээ татварын дарамтаас ангижуулна.
- Татварын байцаагч иргэд, аж ахуй нэгж байгууллагыг тorgууль, захиргааны хэм хэмжээгээр дарамталдаг бус, зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлд шинэчлэлийг хийнэ.
- ААНОАТ, НӨАТ, санхүүгийн лизинг, гаалийн болон татварын системийг аж ахуй нэгж, байгууллагыг илүү орлого олох, өргөжин томрох, олон ажлын байрыг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлд хөгжүүлнэ.
- Өөр хоорондоо зөрчилтэй татварын санхүү, бүртгэлийн хууль, журмуудыг уялдуулж цэгцэлнэ.
- 2016-2020 онд шинээр бий болгосон болон хувь хэмжээг нэмэгдүүлсэн бүх төрлийн татвар, хураамжийг өмнө нь дагаж мөрдөж байсан хувь хэмжээнд хүртэл бууруулна.
- Үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад ашиглах түүхий эд, тоног төхөөрөмжийг Монгол Улсын хилээр оруулахад Гаалийн болон НӨАТ хөнгөлөлт, чөлөөлөлт олгоно.
- Боловсролын тэтгэлэгт зарцуулсан аж ахуйн нэгжийн зардлыг татвар тооцох орлогоос чөлөөлнө.
- Түрээсийн орон сууц барьж, ашиглалтад оруулсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Мөнгөний бодлого

- Төв банкны мөнгө зээлийн бодлогыг Засгийн газрын санхүү төсвийн бодлоготой нягт уялдуулж, инфляцын эсрэг макро эдийн засгийн нэгдмэл, үр өгөөжтэй бодлогыг хэрэгжүүлнэ.
- Инфляцыг нам, тогтвортой түвшинд байлгаж, бизнесийн орчныг дэмжсэн хүү, ханш, зээлийн бодлогыг хэрэгжүүлнэ. Зээлийн хүүг үе шаттайгаар бууруулж, нэг оронтой тоонд оруулна.
- Монгол төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой өсгөж, иргэдийнхээ амьжиргааг ханшийн эрсдэлээс хамгаалах хүрээнд мөнгө санхүүгийн зохистой бодлогыг авч хэрэгжүүлнэ.
- Гадаад валютын улсын нөөцийг тогтмол арвижуулах, валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулахыг дэмжсэн бодлого арга хэмжээг авч, иргэд аж ахуй нэгж байгууллагуудын зээлийн хүртээмжийг сайжруулна.
- Банк, санхүүгийн байгууллагаас олгох зээлийн төрөл, салбар, нөхцөлийг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулна.



Санхүүгийн зах зээл

- Олон улсын жишигт нийцсэн, өндөр үр ашигтай санхүүгийн зах зээлийг бий болгож, иргэд олон нийтэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- Санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын уялдаатай бодлогыг хэрэгжүүлж, нэгдсэн хяналт зохицуулалтын байгууллагыг бий болгож, чадавхжуулна.
- Олон улсад зөвшөөрөгдсөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн хөшүүргийн бодлогоор дэмжиж, хөрвөдөггүй хувьцааны эзэмшлийн төвлөрлийг задлах шийдэмгийг арга хэмжээ авна. Хөрөнгийн зах зээлийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчин болгох арга хэмжээ авна.
- Төрийн өмчит аж ахуйн нэгжийг нээлттэй хувьцаат компани болгон биржээр хувьчилж, ил тод, нээлттэй засаглалыг нэвтрүүлнэ.
- Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд шударга өрсөлдөөнийг бий болгож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоо бүрдүүлнэ.
- Банкнуудын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг шинэчилнэ.
- Монголын хөрөнгийн бирж, төлбөр тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн байгууллагын төрийн оролцоог багасгаж, хувьчилж, нээлттэй хувьцаат компани болгоно.
- Хөрөнгийн зах зээлийн зөвлөн болон хатуу дэд бүтцийг гадаад зах зээлд нийцтэйгээр бүрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Засаглалыг сайжруулах, нягтлан

17



бодох бүртгэл, аудитын чанар, хяналт шалгалтын үр дүнтэй арга хэлбэрийг хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.

- Санхүүгийн чөлөөт бус байгуулах ажлыг эрчимжүүлж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Бус нутгийн банк, санхүүгийн төв болно.
- Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг ашигласнаар иргэн аж ахуйн нэгжид бий болох ашгийн бодит хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.
- Технологид сууринсан санхүүгийн үйлчилгээг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бэлэн мөнгөний гүйлгээг 50% -иар багасгана.

Баялгийн удирдлага

- Байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсвийн орлогоос тусгаарлаж, үндэсний баялгийн санд хуримтлуулан, мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр удирдуулж арвижуулна.
- Төсөвт хуваарилснаас бусад орлогын (өгөөж)-ийг эдийн засгийн төрөлжилт, тэлэлтийг дэмжих, байгалийн нөөцийг хамгаалах, хүний нөөцийг чадавхжуулах, технологийн дэмжлэг үзүүлэх, инкубаторуудыг дэмжих, эдийн засгийн үр өгөөж бүхий капитал бий болгоход ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- “Баялгийн сангийн тухай” хуулийг батална.
- Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу “төрийн нийтийн өмчит компанийн тухай” хууль батална.

Хөдөлмөрийн зах зээл

- Ядуурлын түвшинг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогыг баримт бичигт заасан түвшинд хүргэж бууруулна..Цалин, хөдөлмөрийн хөлсний , уян хатан бодлого хэрэгжүүлж, цагийн хөлсний системд шилжинэ
- Эрдэс баялгийн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгоно.
- 800,000 жуулчин хүлээн авах хүчин чадалтай аялал жуулчлалын салбартай болно.
- Төрийн албанаас эрт тэтгэвртээ гарч жижиг дунд, бичил бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.
- Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийг өсөн нэмэгдэж буй шинэ ажлын байрны хэрэгцээ шаардлагатай нийцүүлэх замаар шинэ төгсөгч оюутан бүрийг үе шаттайгаар хөдөлмөрийн зах зээл дээр ажлын байр бий болгож, хангана.

2.3. Төрөлжилтийн бодлого

- Төрөөс аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Технологийн шинэчлэл, цахим мэдээллийн сан, орон зайн мэдээнд тулгуурласан аж үйлдвэрлэлийн нэгдсэн төлөвлөлтийн зурагт үндэслэн олборлох болон боловсруулах салбарыг дэмжиж, улс орны хөгжлийн тулгуур салбар болгоно. Хөнгөн аж үйлдвэрүүдийг ажлын байр бий болгогч үндсэн салбаруудын нэг болгохын тулд татвар, нэмэгдсэн өртийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл дээр уян хатан бодлого баримтална. Гадаад зах зээл рүү холбох экспортын үйлчилгээг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр үзүүлдэг болно. Засаглалын эрүүл орчныг бий болгож, хөрөнгө оруулагчдын итгэл сонирхол татах орчныг төгс бүрдүүлнэ.
- Монголын Алтыг Монголдоо үлдээнэ. Төмөрлөгийн үйлдвэрлэлийг сэргээнэ. Газрын тос олборлогч орноос шатахуун үйлдвэрлэгч орон болно. Геологи хайгуулын үйл ажиллагааг олон улсын төвшинд хүргэж шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан арвин баялаг нөөц бүхий цахим мэдээллийн сантай болно. Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн эдийн засгийн тулгуур болгоно.
- Эдийн засгийн өсөлтийг хангасан, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй авто замын сүлжээг бий болгоно. Авто замын салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тогтвортой удирдлага зохион байгуулалтын бүтцийг бий болгоно. Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хараат байдлаас гаргах, тохируулгын эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох хүрээнд усан цахилгаан станцуудыг барих ажлыг эхлүүлнэ. Төв, баруун, зүүн болон зүүн өмнөд бүсийн эрчим хүчний системүүдийг цахилгаан дамжуулах шугамаар холбон бүс нутгийн цахилгаан хангамж, найдвартай ажиллагааг сайжруулна.
- Орон сууцны ипотекийг сэргээнэ. Далд эдийн засгийг хязгаарлах зорилгоор зах зээлийн мэдээллийг бүрэн ил тод болгох арга хэмжээ авна. Барилгын компанийн тайлан балансуудыг ил тод болгох замаар хөрөнгө оруулалт татах боломжийг сайжруулна. Саарал жагсаалтаас гаргах цогц арга хэмжээний хүрээнд барилгын салбар дахь санхүү, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын тогтолцоог ил тод мэдээлдэг болгоно. Үндэсний орон сууцны санхүүжилтийн тогтолцоог шинэчилнэ.
- Агаарын болон авто зам, төмөр замын хүчин чадлыг сайжруулж, шаардлагатай шинэ сүлжээг бий болгох замаар аялал жуулчлалын хөгжлийг дэмжсэн дэд бүтцийг бий болгоно. Аялал жуулчлалын талаар баримтлах төрийн болон орон нутгийн бодлогын нэгдмэл байдлыг хангана. Олон улсын стандартыг нэвтрүүлнэ.


Аж үйлдвэрлэлийн салбар

- Өрсөлдөх чадвар бүхий түүхий эд, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Экспортын гол түүхий эдээ боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох замаар үнэ цэнийг нь өсгөнө.
- Эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төслүүдийг хэрэгжүүлэх Засгийн газрын төлөвлөгөө, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих үр ашигтай зохицуулалтыг бий болгож, Худалдаа, эдийн засгийн асуудлыг хариуцах чадварлаг институтүүдийг ажиллуулна.
- Ган, ширэм, зэс, нүүрс-химийн болон газрын тос, газрын ховор элементийг боловсруулах үйлдвэрүүдийг бүс нутгийн нөхцөл, зах зээлийн байдалтай уялдуулж, байгалийн нөөцөд тулгуурлан үе шаттайгаар барьж байгуулна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өргөтгөл жилд 200 мянган тонн шууд ангижуулсан төмрийн үйлдвэр зэрэг бүтээн байгуулалтыг дэмжинэ.
- Эдийн засгаа уул уурхайн салбараас хэт хараат байдлаас гаргах зорилгоор төрөлжүүлж, хөнгөн-хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, мэдлэгийн эдийн засгийн бусад салбаруудын өсөлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Эрчим хүчний хямд түүхий эд экспортлохыг багасгаж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болох цахилгаан, эрчим хүчийг Ази-номхон далайн зах зээлд нийлүүлэх гарц бий болгоно.
- Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоо бий болгох, олон улсын стандарт нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Дарханы арьс ширний цогцолборыг барьж, ашиглалтад оруулах ажлыг дэмжинэ.
- Говьсүмбэр аймгийн нутагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулж жилд 16 сая тонн нүүрснээс кокс, улмаар 15.0 сая тонн ширэм, ган үйлдвэрлэн экспортлох хар төмөрлөгийн цогцолборыг ашиглалтад оруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- Газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсний гүн боловсруулалт (нүүрс хийжүүлэх, нүүрснээс байгалийн нийлэг хий ялгаруулах), нүүрсний давхаргын метан хий олборлох, ашиглах төслүүд, Чойрт нүүрс-химийн үйлдвэр зэрэг үйлдвэрүүдийг уламжлалт бус газрын тосны салбарын цогц төлөвлөлтийн хүрээнд дэмжиж, ашиглалтад оруулна.
- Жилд 500 мянган тонн зэс, 20 мянган тонн алт хайлуулах үйлдвэрийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулах бодлого баримтална.
- Машин, механизм, тээврийн хэрэгсэл, уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн цогц төлөвлөгөө хэрэгжүүлнэ.
- Хөдөө аж ахуй салбарт боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс ширний бүтээгдэхүүний экспортыг эрс өсгөнө.



Эрдэс баялгийн салбар

- Эрдэс баялгийн нөөцийг өсгөх бодлого баримтална. Ашигт малтмалын эрэл хайгуулын зөвшөөрлийг олон улсын стандартын дагуу олгож эхэлнэ.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн ашигт малтмалыг олборлож, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох боломжтой үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.
- Төрийн нийтийн зориулалттай зарим өмч (газар, газрын хэвлий, ус, ой, тэдгээрийн доторх болон дагалдах баялаг)-ийг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах нөхцөл, журмыг хуулиар тогтооно.
- Геологи, уул уурхай, эрчим хүч, барилгын салбаруудад үндэсний хэмжээний бүтээн байгуулалтын том төслүүдийг хэрэгжүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжинэ. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, Таван Толгойн ордыг түшиглэн Кокс-химиийн үйлдвэр барих, Дархан-Сэлэнгийн бус нутгийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн металлургийн цогцолбор, Вольфрамын баяжмал гүн боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах ажлыг дэмжинэ.
- Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг шинэчилж, нийтлэг стандартуудыг тогтооно. Иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандaa хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгох, аюулгүй ажиллагааны хариуцлагыг чангатган “Уул уурхайн хайтуул болон олборлолт, хаалтын аюулгүйн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Уул уурхайн салбарт нөхөн сэргээх шаардлагатай газруудад үйл ажиллагааг нь санхүүжүүлэх зорилго (нөхөн сэргээлтийн дэнчин, бонд) бүхий хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.
- Стратегийн ордуудын өгөөжийг өсгөх бодлогыг тууштай баримтална. Монгол улсын иргэн бүр хувьцааг нь эзэмшдэг Эрдэнэс Таван Толгой хувьцаат компанийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна. Иргэн бүрийн эзэмшиж буй 1072 ширхэг хувьцаанд оногдох өгөөжийг нэмэгдүүлж, компанийн үйл ажиллагаанд оролцох, нээлттэй ил тод мэдээллээр хангагдах, компанийн удирдлагын үйл ажиллагаанд төлөөллөө оролцуулах, ногдол авах эрхийг нь хуулиар баталгаажуулна.
- Төрийн өмчит “Эрдэнэт УҮГ”-ын хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах замаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлнэ.
- “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр ажиллах нөхцөлийг журамлаж, бүртгэх, гарал үүслийн гэрчилгээ олгох замаар хоршиж ажиллах боломжийг бий болгоно. Ингэснээр дундын зуучлагч, ченжүүдийг албан ёсны бүртгэлд хамруулан алтны хууль бус наймааг таслан зогсооно.




- Газрын тос, метан хий, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, ашиглалтыг эрчимжүүлнэ.
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг дэмжинэ. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт тавих олон улсын стандартад нийцсэн итгэмжлэгдсэн лабораторийг шинэчилж, иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангана.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн сан (агуулах) байгуулж, гадаад зэх зээлийн нөхцөл байдал, давагдашгүй нөхцөл үүсэхэд үнийн өсөлтөөс хамгаалах хеджингийн арга хэрэгслийг ашиглах, удирдах чадварыг хөгжүүлнэ.
- Метан хийн дэд бүтцийн төлөвлөлтийг хийж, шинэ үйлдвэр, хот суурин газрын бүтээн байгуулалтад ашиглана.
- Газрын ховор элементийн салбарт хөрөнгө оруулалтыг татах хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

Дэд бүтэц

- Эдийн засгийн өсөлтийн суурь болсон хатуу болон зөөлөн дэд бүтэц (зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.
- Улаанбаатар дахь Олон улсын нисэх буудлыг авто, төмөр замын буудал бүхий зорчигч тээврийн нэгдсэн зангилаа болгоно.
- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн хүрээнд барьж байгуулах төмөр замын барилга байгууламжийг барих ажлыг эрчимжүүлнэ. Уул уурхай, ашигт малтмалын ордын бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын болон аялал жуулчлалын бус нутгийг холбосон замыг төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.
- Агаарын тээврийг либераллах, газарзүйн байршлын давуу талаа ашиглан агаарын тээврийн бус нутгийн зангилаа төв болгоно.
- Нийслэлд “Гудамж төслийг” үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинээр барьж түгжрэлийг бууруулна.
- Монгол Улсаас хөрш орнуудтай байгуулсан авто-тээврийн хэлэлцээрийн дагуу ашигт малтмалын тээвэрлэлтийн зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үндэсний тээвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хот доторх нийтийн тээврийн парк шинэчлэлтийг цахилгаан автобусаар бүрдүүлж, чиглэлийн болон тусгай замын тээвэр, таксины үйлчилгээг үе шаттайгаар шинэчилнэ.
- Улаанбаатар хотын дотор тээвэрлэлт хийж байгаа аюултай ачааны тээвэрлэлтийг тусгай цагийн хуваарь, маршрутаар зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлүүлнэ.

- Хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаанд нөхөн олговор олгох болон парк шинэчлэлт хийхэд төрөөс бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- Улс хоорондын болон олон улсын тээврийг төрийн бодлогын хэмжээнд дэмжиж Тяньжин – Улаанбаатар - Улаан-Үд – Улаанбаатар – Тяньжин чиглэлийн 3 улсын дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлнэ. “Талын зам” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- Улаанбаатар - Европын холбооны улс руу ачаа транзит тээвэр гүйцэтгэх Монголын тээвэрчдийг бэлтгэх Евростандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг төрөөс бодлогоор дэмжинэ.
- Төмөр замын сүлжээг өргөтгөж, технологийг шинэчлэн тээвэрлэлтийн хурдыг нэмэгдүүлнэ. Төмөр замчдын нийгмийн баталгааг хангана.
- Улаанбаатар хотын төвийг дайран өнгөрч байгаа төмөр замыг нүүлгэн шилжүүлэх “Богд хан төмөр зам”-ын төслийг хэрэгжүүлнэ.
- Агаарын тээврийг либералчлах, газарзүйн байршлын давуу талаа ашиглан агаарын тээврийн бус нутгийн зангилаа төв болгоно.
- Авто замын сүлжээг хөгжүүлэхээр батлагдсан төсөл хөтөлбөрүүдэд судалгаа хийж олон улс, улс, орон нутгийн чанартай авто замын сүлжээг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.
- Авто замын зурvas газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч авто замын үндсэн хөрөнгө дээр нэмэн үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эхлүүлнэ
- Орон нутгийн авто замын сүлжээг бий болгоно. /Сумдын төвийг хямд өртөгтэй авто замаар аймгийн төвтэй нь холбох ажлыг эхлүүлнэ./
- Хилийн боомтуудыг хатуу хучилттай хямд өртөгтэй авто замаар холбоно.
- Аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээг бий болгоно.
- Уул уурхай, ашигт малтмалын ордын бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын болон аялал жуулчлалын бус нутгийг холбосон замыг төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.
- Олон улс чанартай авто замуудыг камержуулж, 150-200 км тутамд зорчигч үйлчилгээний төвүүдийг барина.
- Олон улс, улс, орон нутгийн чанартай авто замын засвар арчлалтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Авто зам ашигласны төлбөр хураах асуудлыг цогцоор нь судлан цахим хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлнэ.
- Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн түгжрэлийг бууруулах зорилгоор автозамын сүлжээ төлөвлөлтийг шинэчилж, тээврийн төлөвлөлтийг олон улсын жишигт хүргэнэ.
- Шинэ нүүрс, зэсийн уурхайн болон холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжинэ.
- Далайд гарцгүй манай орны баруун бүсийн ашигт малтмалыг экспортод гаргах, бус нутгийн хөгжлийн бодлого, эрчим хүч, усан хангамжийн нэгдсэн сүлжээг цогцоор нь байгуулахад хувийн хэвшил, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллана.



- Орос Хятадыг холбосон авто зам, төмөр зам, хий дамжуулах хоолой, эрчим хүчний шугам, нефтийн хоолойн бүтээн байгуулалт (2013 оны 3-р сард зарласан Талын зам төсөл)-ыг сэргээн үргэлжлүүлнэ.
- Орос Хятадыг холбосон Арцсуурь-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам (Завхан, Говь-Алтай, Баянхонгорын аймгийн нутгаар)-ыг бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан төслүүдийг үе шаттай дэмжинэ.
- Шинэ нисэх онгоцны буудалд түшиглэсэн худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн чөлөөт бүс байгуулна.

Эрчим хүч

- Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын загварыг боловсронгуй болгон зах зээлийн зарчимд тулгуурласан, хэрэглэгчдэд ээлтэй уян хатан систем нэвтрүүлнэ.
- Эрчим хүчний салбарын цогц хөгжлийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу баталж, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бодлогыг баримтална. Үүнд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.
- Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хараат байдлаас гаргах, тохируулгын эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох хүрээнд усан цахилгаан станц, болон цахилгаан хуримтлуурыг барьж байгуулна. Таван толгойн цахилгаан станц, Багануурын цахилгаан станцын төслүүдийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг ашиглалтад оруулна.
- Дорнод болон Баруун бүсийн эрчим хүчийг тус бүр 100 МВт хүртэл чадалтай цахилгаан станц барих төсөл судалгааг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн уурхай, цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам бүхий цахилгаан экспортлох цогцолбор байгуулах төслийг дэмжиж, хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох харилцан ашигтай гэрээ байгуулж ажиллана.
- Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барихад төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг түлхүү баримтална.
- Аймгийн төвүүдэд дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулна
- Төв, баруун, зүүн болон зүүн өмнөд бүсийн эрчим хүчний системүүдийг нэвтрүүлэх чадвар өндөртэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцуудыг ашиглалтад оруулан бүс нутгийн цахилгаан хангамж, найдвартай ажиллагааг сайжруулна.
- Шинэ бүтээн байгуулалт, шинэ суурьшлын бүс, хот суурин газрыг дулааны эрчим хүчээр найдвартай хангах техник, технологийн боломжийг бүрдүүлнэ.

- Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх замаар Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлыг хувийн хөрөнгө оруулагчдыг дэмжих замаар хэрэгжүүлнэ.
- Өрх бүр эрчим хүч үйлдвэрлэгч болох, алслагдсан жижиг хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, эрчим хүчний хэмнэлттэй эко төслүүдийг төрийн бодлогоор дэмжинэ. Тархмал эх үүсвэрийг барьж байгуулах асуудлыг судалж, шийдвэр гаргана.
- Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.
- Эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай хямд эх үүсвэр болох нүүрсний давхаргын метан хийг ашиглах, дамжуулах дэд бүтцийг бий болгох судалгааны ажлыг эхлүүлнэ.
- Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын түлшний хэрэглээг аюулгүй болгох, агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгах, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолгүй болгоно.

Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа


- Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ. Шуудангийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэж, хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг 3 дахин ихэсгэнэ. Монгол Улсыг бүрэн хамарсан сансрын радио сүлжээг бий болгоно.
- Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Иргэдэд зориулсан цахим боловсролын төвүүдийг байгуулна.
- Технологийн дэвшлийг ашиглан бэлэн мөнгөний гүйлгээг 50% багасгаж, эдийн засгийн эрүүл тогтолцоог бий болгоно.
- Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын технологийг нутагшуулна. Уламжлалт үйлдвэрлэлийг шинэ технологийн бодлогоор дэмжиж ажиллана.
- Шуудангийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэж, хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг 3 дахин ихэсгэнэ.
- Судалгааны гадаад хамтыг ажиллагааг 2 дахин ихэсгэнэ. Шинжлэх ухаан боловсролын байгууллагуудын нэгдсэн үндэсний Шинжлэх ухаан боловсролын сүлжээг үүсгэнэ.
- Инновацад суурилсан гарааны бизнесүүдийг дэмжинэ. Гарааны бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлнэ.
- Их дээд сургуулиудыг судалгааны байгууллага болгох чиглэлээр ажиллана. Шинжлэх ухааныг төрөөс дэмжих хүрээнд үйлдвэрлэл, бизнестэй уялдсан судалгаа, шинжилгээний тогтолцоог дэмжинэ.

Барилгын салбар

- Дотоодын нийт бүтээгдэхүүнийг 50 их наяд төгрөгт хүргэх нэмэлт боломжийг барилгын салбараас бүрдүүлнэ. “Найман хувийн” хөтөлбөрийг сэргээн үргэлжлүүлж, хүүг бууруулна.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэх замаар хөрсний бохирдлыг эрс бууруулна.
- Барилгын салбарт ажиллагсдын эрүүл мэнд, санхүүгийн эрх эрсдэлийг бууруулна. Зохион байгуулалттай хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжих замаар цагийн ажлын тогтолцоог урамшуулна.
- Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ. Банкнуудын зээлийн багцыг оновчтой болгох замаар Жижиг дунд үйлдвэрүүдэд олгох зээлийн хүртээмжийг өсгөхийн тулд хоёрдогч зах зээлийн тогтолцоог төгөлдөржүүлнэ.
- Улаанбаатар хотын баруун ба зүүн захад логистикийн төвүүдийг байгуулах замаар барилгын салбарын тээврийн өртгийг бууруулна. Нийслэл хотын түгжрэлийг багасгана.
- Хөдөө орон нутагт аймгийн иргэдийн төлөөлөгч, засаг дарга нарын хийсэн дахин төлөвлөлтийн ажлыг дэмжих хүрээнд юуны түрүүнд 1960-аад онд барилгажсан аймгийн төвүүдэд төсвийн уян хатан бодлого (татварын хөнгөлөлт) хэрэгжүүлнэ.
- Баялгийн сангийн дэргэд Иргэдийг орон сууцаар хангах дэд сан байгуулж, Засгийн газар ба Монгол банк дээр байх давуу эрхийн бондуудыг шилжүүлэх шийдвэрийг УИХ гаргана. Тус дэд санг үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр идэвхтэй оролцуулна.
- Орон нутагт хотжилтыг дэмжих зорилгоор Дархан-Сэлэнгийн бүсэд барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Аялал жуулчлал

- Спортын, эрүүл мэндийн, эко-туризмын, нүүдэлчний өв соёлоо сурталчлах зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг хөхүүлэн дэмжинэ.
- Аялал жуулчлалд тээврийн эрэлт хэрэгцээг хангахын тулд агаарын болон төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй, уян хатан байдлыг нь сайжруулна.
- Жуулчлалаас орж ирэх эдийн засгийн асуудлыг шинэчлэн төлөвлөж, төрийн бүх түвшинд салбаруудын хамтын ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалын талаарх Үндэсний бодлого, төлөвлөгөөг бүсийн болон орон нутгийн төр захиргааны төлөвлөлтөд тусгана.
- Орон нутгийн иргэд, олон нийтийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчиний ур чадварыг хөгжүүлнэ.



- Монголд жуулчилж, аялах эрэлтийг нэмэгдүүлэх, эргэлтийг нь сайжруулах зорилгоор түншлэл, үр ашиг, боломжийг тодорхойлж төлөвлөн, маркетингд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- Монгол улсын хил дээр зорчигч өөртөө үйлчлэх SmartGate болон eGate паспортын технологийг нэвтрүүлж, хилийн цэгүүд дээр өргөжүүлнэ.
- Хорио цээрийн хяналтыг шуурхай болгох чиглэлээр хилийн цэгүүд дээр шинэчлэл хийнэ.
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүний худалдан авалтаас жуулчдад татвар буцаан олгох схемийг нэвтрүүлнэ.
- Нисэх онгоцны буудлаас жуулчдын очих гол цэгүүд рүү хүрэх нийтийн тээврийн болон тусгай автобусны хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулна.
- Хилийн болон нисэх онгоцны буудлын ажилтнууд, шалган нэвтрүүлэх цэг дээрх менежментийг зохион байгуулахад аялал жуулчлалын салбарын түншүүдтэй хамтран ажиллаж жуулчдыг шуурхай мэдээллээр хангана.
- Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогод тусгагдсан байгалийн онцгой үзэсгэлэнт газар, тусгай хамгаалалттай газруудад хэрэгжих олон улсын байгууллагын болон хувийн хэвшлийн санаачилга хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийг бодлогоор дэмжинэ

Хүнсний үйлдвэрлэл


- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлж, “Эрүүл хүнс” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг үндэсний үйлдвэрлэлээр бүрэн хангаж, эрүүл, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлнэ.
- Ерөнхий боловсролын системд “Хүнсний тухай боловсрол” олгох үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.
- Хүнсний бүтээгдэхүүний лабораториудыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага болон хувийн хэвшилд шилжүүлж, төрийн болон мэргэжлийн хувийн байцаагч нарын нөлөөллөөс гаргана.
- Стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг өргөжүүлж, элсэн чихэр, ургамлын тосны хангамжийг хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.
- Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулж, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс бүхий орон bolj, улмаар экспортлох боломжийг нэмэгдүүлэх. Энэ зорилтод хүрэхийн тулд дараах арга хэмжээг нэмэгдүүлнэ.




- Органик хүнс үйлдвэрлэлийн тогтолцоонд ахиц дэвшил гаргаж, гадаадын зорилтот зах зээлд нэмүү өртөг шингэсэн эх орны органик хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
- Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай, органик, эко хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж, экспортлох хэмжээг нэмэгдүүлнэ.
- Жимс, жимсгэнэ, элсэн чихэр, ургамлын тосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.
- Хот суурин газрын болон хөдөө орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- Импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тэргүүн ээлжид хөгжүүлж, татвар, урамшууллын бодлогоор дэмжинэ.
- Хүнсний эрүүл ахуйн олон улсын стандартыг улс орон даяар мөрдүүлэх, мэдээллийн технологийн шийдэлд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, мөшгөлтийн тогтолцоонд шилжих зорилтыг 2020 оноос эрчимтэй хэрэгжүүлж эхэлнэ.
- Блокчейн технологийг ашиглан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, нэмүү өртгийн сүлжээнд мөшгөлтийн технологийг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдал болон экспортын баталгаажилтыг нэмэгдүүлнэ.
- Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг боловсронгуй болгож, хүн амын хэрэгцээнд эрүүл, чанартай хүнс нийлүүлэх боломж нөхцөлийг сайжруулна.
- Хүнсний хяналтын тогтолцоог орчин үеийн ухаалаг технологид тулгуурлан төгөлдөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх лабораторийг мэргэжлийн холбоод болон хувийн хэвшилд шилжүүлнэ.
- Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хот, суурин газрын хүн амыг эрүүл, чанартай усаар хангах дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Хөнгөн үйлдвэрлэл

- Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэлийн төвүүдийг бодлогоор дэмжинэ.
- Хөнгөн үйлдвэрлэлийн зээл, тусламжийг бодлогоор татах, гаднын донор байгууллагуудын зээл, тусламжийг бодлогоор чиглүүлнэ.
- Экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуй-хөнгөн үйлдвэрлэлийн кластерийг аймгийн түвшинд хөгжүүлэхийг дэмжинэ.





- Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож, үндэсний бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Багахангай, Налайх, Эмээлтэд үйл ажиллагаа эрхлэх үйлдвэр технологийн паркуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.

Бүтээлч үйлдвэрлэл

- Оюуны үйлдвэрлэлийг дэмжиж АиТи, оутсоурсингийн зөвлөн дэд бүтцийг бүрдүүлэх замаар экспортын салбар болгон бойжуулна.
- Үндэсний кино үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, кластер байгуулна.
- Контент бизнесийг дэмжих замаар Монгол үндэстний өв соёлыг сурталчилна.
- Зайнаас ажиллах боломжтой залуучуудад зориулсан цахим ажлын 10,000 байрыг бий болгоно.
- Үндэсний зураг, анимэшн, манга ба бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.



ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

3.1. Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилнэ.


Бүсчилсэн хөгжил

- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн батална.
- Бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ хил залгаа аймаг болон хөрш улсуудын зах зээлийн нөхцөл, дотоодын үйлдвэрлэлийн чадавх, дэд бүтцийн боломжид тулгуурлана.
- Тухайн бүс нутгийн аймаг, хот тус бүр хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбараа тодорхойлж, хөгжлийн бодлогоо уялдуулан хамтарч хөгжихийг дэмжиж, дэд бүтцийн барилга, байгууламж, тээвэр, логистикийн сүлжээг бий болгоно.
- Бизнесийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ. Татвар, нийгмийн даатгал, цалин хөлс, хөдөлмөрийн үнэлгээний ялгаатай бодлого хэрэгжүүлнэ.
- Хөрш улсуудтай хийх худалдааны таатай нөхцөл, хил гаалийн боомт, шууд нэвтрэх зам, тээврийн дэд бүтцийг бүрдүүлж, эдийн засгийн харилцан ашигтай, хамтын ажиллагааг дэмжинэ.
- Бүсийн эдийн засаг, санхүүгийн төвийг дэмжсэн санхүүгийн зуучлал, хөрөнгө оруулалтын үйлчилгээг төрийн бодлогоор дэмжинэ.

3.2. Орон нутгийн хөгжил

- Орон нутаг, хот тосгоны үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн баталж, засаглалын хэлбэр, чадавхыг бэхжүүлнэ.
- Эдийн засгийн бие даасан байдлыг хангах, төсөв бүрдүүлэх, зарцуулах эрхийг нэмэгдүүлнэ.
- Бүс нутаг, газар зүйн онцлог, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, хүн амын суурьшлын бодлоготой уялдсан татварын ялгаатай бодлого хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг дэмждэг Орон нутгийн хөгжлийн санг зөвхөн төсвийн хөрөнгөөр бус олон хэлбэрт эх үүсвэрээс бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгоно. Орон нутгийн хөгжлийн санг захиран зарцуулах эрхийг иргэдийн оролцоотой төлөөллийн байгууллагаар урьдчилан дүгнүүлдэг үр ашигтай, хэмнэлттэй төсөв, аудит хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

30



- Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын 30 хүртэлх хувийг орон нутагт нь шууд хуваарилдаг тогтолцоог бурдүүлнэ.
- Орон нутгийн хөгжлийг дэмжих аж үйлдвэрлэл, олборлох, боловсруулах, хөнгөн, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн томоохон төслийг санхүүжүүлэх зорилгоор Төрийн банкийг орон нутгийн хөгжлийг дэмжих төрөлжсөн үйлчилгээтэй жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих банк болгон өөрчлөн зохион байгуулна.
- Орон нутаг өөрсдийн төсвийн орлогыг барьцаалан хөгжлийн бонд, санхүүгийн хэрэгсэл ашиглах эрхийг хуулиар бий болгоно.
- Хөдөөгийн орчинд тохирсон хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны байгууллагууд, санхүүгийн зуучлалын бусад хэлбэрийг орон нутагт хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- Орон нутгийн төрийн худалдан авалтын үйл ажиллагааг орон нутагтаа сонгон шалгаруулдаг, зөвхөн дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг тогтолцоонд шилжинэ.
- Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг орон нутгийн инновацын сангаас санхүүжүүлнэ. Орон нутаг бүр инновацын сантай байх хууль батална.

“Шинэ хөдөө” хөтөлбөр

- Уламжлалт мал, аж ахуйн гаралтай түүхий эд ноос, ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тордолгооны цэгт бэлтгэн бус нутаг, аймгийн төвүүдэд боловсруулж, өндөр түвшний технологийн үйлдвэрт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын болон гадаад зах зээл дээр өрсөлдөх үнээр борлуулах боломжийг бурдүүлнэ.
- Түүхий эд үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэр, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулагч талууд корпорац болон кластерийн тогтолцоогоор хамтран ажиллах загварыг дэмжинэ.

Иргэдийн оролцоотой “Шинэ сум” төсөл

- Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сууриныг хөгжүүлнэ. Сумын шинэчлэлийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- Сумын шинэчлэлийн төслийг хүрээнд Монгол Улсын 330 сумдыг үе шаттайгаар шинэчилнэ.

“Чинээлэг малчин” хөтөлбөр



- Мал аж ахуй салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Иргэдийн санаачилгад суурилсан Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг дэмжинэ.

3.3 Бэлчээр ашиглалт

- Бэлчээр ашиглалтын тухай эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- “Хариуцлагатай нүүдэлчид” хөтөлбөрийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг мөшгөх тогтолцоог бүрдүүлнэ.
- Малчдын хамтын оролцонд тулгуурлан Монгол орны газар нутгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
- Ямаан сүргийн зохистой харьцааг шинжлэх ухааны үндэстэй тогтооно. Ноолуур ба ноолууран бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд зөв сурталчилна.
- Малын хөлийн татварын тогтолцоог бүрдүүлж, тус орлогыг тухайн орон нутгийн төсвөөр дамжуулан бэлчээрийн нөхөн сэргээлтэд зориулна.
- Бэлчээрийн зохистой менежментийн төрийн бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.4. Мал аж ахуй

- Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг төрийн бодлогоор дэмжинэ.
- Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг орон даяар хэрэгжүүлнэ.
- Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.

3.5. Газар тариалан

- Газар тариаланг урамшуулах бодлогыг шинэчилнэ. Үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг

уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.

- Ургамал хамгаалах химиин бодис болон бордоо болон био бэлдмэлийн ухаалаг хяналтыг бий болгоно.
- Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- Экспортод чиглэсэн өндөр ашиг шимт эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогын орчныг сайжруулна.
- Газрын үржил шимийг хамгаалан зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлнэ.
- Тариалангийн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ газрын үржил шимийг хамгаалах, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн технологи, инновацын шинэчлэл хийж, “Ухаалаг газар тариалан” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцоор хөгжүүлж, үрийн сорт сорилт, чанарыг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нутагшсан сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн техник хангамжийн түвшнийг дээшлүүлнэ.
- Ургамал хамгааллын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- Эрдэс болон органик гаралтай бордооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.
- Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжин, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор жилийн турш хангана.
- Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг орлох чанартай, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.6. Нийслэл хот, хотуудын хөгжил

Нийслэл Улаанбаатар хот



- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталж, Улаанбаатар хотын хэмжээнд хотын төлөвлөлт, бүсчлэл, хөгжил, дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэдэг болгож, төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойр дүүргийн засаг захиргаа хүргэдэг засаглалын оновчтой тогтолцооны эрх зүйн үндсийг тавина.
- Нийслэлийн удирдлага, менежментийг тогтолцоог ухаалаг, боловсронгуй болгоно.
- Нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хяналтын хувьцааг IPO хийх замаар олон нийтийн өмчийн оролцоотой болгож, удирдлага менежментийг сайжруулж, компанийн сайн засаглалын хөгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.
- Улаанбаатар хотыг нүхэн жорлонгүй болгох хөтөлбөрийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернет шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшинаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.
- Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшинаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна.
- Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд “Эрчим хүч үйлдвэрлэгч иргэн” хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандaa нар салхины сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний сүлжээнд худалдан борлуулахыг дэмжинэ.
- Хуучны угсармал орон сууцны дулааны алдагдлыг бууруулах зорилгоор дулаалах төслийг хэрэгжүүлнэ.
- Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулж, иргэд хогоо ангилан ялгаж тушаах, ААН-үүд өөрсдийн гаргаж буй сав баглаа боодлыг буцаан цуглуулан авч, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

34



- Дугуйн болон явган замын сүлжээг илүү нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын гаднах авто машины зогсоолыг төлбөртэй болгож, авто замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, давхар зогсоолуудыг бий болгоно.
- Нийслэлийн зарим гудамжийг явган хүнд зориулагдсан, худалдаа үйлчилгээний “Авто машингүй гудамж” болгоно.
- Цэцэрлэг сургуулийг нэмж барих замаар дүүрэг бүрд бага насын хүүхэд нэг км радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжоор хангана.
- Сургуулийн автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хотын соёлын өв, дурсгалт барилгуудыг нураахгүйгээр, арчлан хамгаалах, сэргээх завсарлах хэлбэрээр сайжруулан соёлын өвийг хойч үедээ үлдээж ажиллана.
- Улаанбаатар хотын гэр хороолол, хотын хөрсний бохирдлыг бууруулах “Ногоон бүс” хөтөлбөр (Сэлбэ, Туул, Дунд голыг сэргээх, хамгаалах, арчлах зорилгоор голын эрэг дагасан ногоон бүс, ойжуулалт хийх) хэрэгжүүлж, хотын нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- Нийслэлийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа иргэдэд нээлттэй тайлагнадаг механизмыг бүрдүүлнэ.

Дагуул ба шинэ хот

- Орон нутаг, нийслэл, дагуул болон засаг захиргааны шинэ хотыг байгуулж, хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- “Майдар сити”, “Аэро Сити” зэрэг дагуул хотуудыг байгуулахыг дэмжинэ.
- Налайх, Багануур дүүргүүдийг дагуул хотын төлөвлөлтийг эхлүүлнэ.



ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авилгаас ангид ажиллах чадавхтай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн, хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.


4.1. Иргэнээ хамгаалдаг хууль

- Иргэний үндсэн эрхийн баталгааг хангах, парламентын засаглалыг бэхжүүлэх, сонгуулийн тогтолцоог холимог болгох, шүүхийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, прокурорын байгууллагыг гүйцэтгэх эрх мэдэлд харьялуулах, Үндсэн хуульд дархлаа бий болгох чиглэлээр Үндсэн хуулийг сайжруулах ажлыг хийнэ.
- Үндсэн хуулийн цэцийг иргэний үндсэн эрхийн баталгааг хамгаалах чиг үүрэгт нийцүүлэн, Үндсэн хуулийн шүүхийн түвшинд ажиллахуйц шинэчлэлийг хийнэ.
- Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар явуулах хууль зүйн болон зохион байгуулалтын баталгааг бий болгоно.
- Прокурор болон өмгөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсдэг тэгш бус байдлыг арилгана.
- Шүүхийн шийдвэр хэрэгжихүйц байх зарчмыг хангаж, шүүх гаргасан шийдвэрээ биелүүлэх нөхцөл, арга замыг шийдвэртэй тусгасан байх шаардлагыг хуульчилж шүүгчийн шийдвэртэй хандах хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, хүний амь нас, бие эрхтэн, сэтгэл санаанд учирсан гэм хор, хохирлыг мөнгөөр нөхөн тооцох аргачлалыг хуульд тусгана. Хохирлыг барагдуулах үндэсний тогтолцоог сайжруулж, шинэ түвшинд гаргана.
- Шүүхийн шинжилгээ, шинжээчийн үйл ажиллагааг хариуцлагатай, ил тод, нээлттэй болгож, бие даасан, өрсөлдөөнт, сонголттой, мэргэжлийн шинжээч, лаборатори бүхий шүүх шинжилгээний тогтолцоотой болно.
- Хууль, шүүхийн байгууллагын албан тушаалтны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдсэн гэмт хэргийг сонирхлын зөрчилгүй, хараат бусаар мөрдөн шалгах тогтолцоог бий болгоно. Энэ төрлийн гэмт хэргийн ял шийтгэлийн бодлогыг чангатгана.
- Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зүй бусаар нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай мэдүүлэг бөглүүлж, хэргийн оролцогчдод ил тод болгоно.
- Хууль, шүүхийн байгууллагын албан тушаалтны ёс зүй, зан харилцаанд тавих олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно.



- Шүүхийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зорилгоор шүүхийн ил тод, нээлттэй байдлыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулна.
- Хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ.
- Олон улсын түвшинд өрсөлдөх, ажиллах чадвартай хуульчдыг бэлтгэх тогтолцоог дэмжин, хууль зүйн дээд боловсролыг олон улсын жишигт нийцүүлэх, шинэчлэх арга хэмжээ авна.
- Хууль зүйн их, дээд сургуульд орой, эчнээ ангид суралцаж төгссөн эрх зүйчдийг нэмэлт кредит хангуулах замаар хуульчийн шалгалт өгөх эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.
- Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтыг нь иргэний болгох чиглэлээр өөрчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.
- Хууль сахиулах ажиллагааг тусгай хуулиар зохицуулна. Хууль сахиулагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг дээшлүүлнэ.
- Хар тамхи, хүн худалдаалах, мөнгө угаах, цахим орчинд үйлдэгдэх зэрэг улс дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх албыг мэргэшүүлж, чиг үүргийг зааглан, гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донточ болсон хүнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарч, яллах зарчмыг урьтал болгохгүй.
- Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цахим орчинд хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээлэл, нууц, өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.
- Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгavarлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- Нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын жишигт хүргэн процессжуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиг үүргийг оновчтой зохион байгуулан, иргэний шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаанд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд мэргэжлийн компани ажиллах боломжийг нээнэ.
- Гамшиг, аюулаас хамгаалах үндэсний бүтэц үүсгэж, үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага болон орон нутгийн иргэдийн хамтын тогтолцоотой болгоно.

- Хил хамгаалах үйл ажиллагааг хүн хүчний бус техник технологийн хяналт давамгайлсан, мэргэжлийн шуурхай бүрэлдэхүүн, хууль сахиулах хүч, иргэний хамтын ажиллагаанд суурилах чиглэлд хөгжүүлнэ.
- Онц байдлын болон хямралт байдлын үеийн зохицуулалтыг боловсронгүй болгож, ухаалаг, үр нөлөөтэй, дэс дараатай ажиллах эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх



4.2. Иргэндээ үйлчилдэг засаглал

- УИХ-ын ил тод, нээлттэй байдал, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог хангах зорилгоор Цахим парламентыг (Цахим УИХ) бий болгоно. Иргэн цахим санаачилга гаргасан, иргэд цахимаар гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг дэвшүүлсэн тохиолдолд УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ шууд авч хэлэлцэх журам тогтооно.
- Хувийн болон бизнесийн явцуу эрх ашгаа хангахын тулд хууль тогтоох ажиллагаанд зүй бусаар нөлөөлж, хуулийг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлж засдаг явдлыг таслан зогсоох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад холбогдох хуулийг боловсронгүй болгох замаар татвар төлөгчдийн мөнгөөр хэрэгжүүлдэг сонгогчдын саналыг худалдан авахад чиглэсэн үр дүнгүй, үрэлгэн аливаа үйл ажиллагаа, төсвийг сонгуульд зориулан боловсруулах явдлыг таслан зогсооно.
- Улс төрийн сонгуульд нэр дэвшигчдээс гаргах сонгуулийн зардал, өртгийг бага болгож, нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог тэгш хангах арга хэмжээ авна.
- Хууль зүй, дотоод хэргийн чиг үүргийг зааглаж, тус тусад нь үр дүнтэй хэрэгжүүлэх зарчмыг баримтална.
- Сонгогдсон, томилогдсон төрийн өндөр албан тушаалтан нь ёс зүйн зөрчил гаргасан бол олон нийтээс учлал гүйх үүргийг хуульчилж, түүнийг огцруулах, чөлөөлөх хууль зүйн үндэслэлийг тодорхой болгох бие даасан хууль батална.
- Авлига, сонирхлын зөрчилд холбогдсон үндэслэлээр албан тушаалтныг огцруулсан тохиолдолд нийтийн албанд дахин ажиллах боломжгүй болгоно.
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг, хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг барагдуулах механизмыг сайжруулна.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг хамгаалж, дэмжих хууль зүйн орчинтой болгоно.
- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах болон урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг салгаж, ардчилсан эрх зүйт төртэй улс орнуудын нийтлэг жишигт хүргэнэ.
- Төрийн албаны удирдах албан тушаалтны тоог бууруулж, дарга нарын тансаглалыг таслан зогсооно.
- Мэргэшсэн нийтийн алба, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоо бүхий нийтийн үйлчилгээг бэхжүүлж, салбарын мэргэшсэн ажилтнуудыг улс төрөөс ангид, тогтвортой ажиллуулах хууль зүйн баталгааг бүрдүүлнэ.

- Авлигатай тэмцэх тэмцлийг эрчимжүүлж, төрийн өндөр албан тушаалтны зарлага болон орлогын албан татвар төлөлтийг ил болгож, уялдуулан хянадаг тогтолцоог бүрдүүлнэ.
- Шүүхийн шийдвэр, үйл ажиллагааг судлан, шүүмжлэх академик эрх чөлөөг уриалан дэмжиж, хуулийн зөв хэрэглээ, хүний эрхийн шаардлагын хүрээнд хийгдсэн дүн шинжилгээ, түүнтэй холбоотой нийтийн хэлэлцүүлэг шүүхийн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх суурь болно гэж үзнэ.
- Монгол Улсын шударга ёс, Хууль дээдлэх ёс, ил тод, нээлттэй байдал, авлигын олон улсын индексийг сайжруулах арга хэмжээ авна.
- Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
- Олон улсын сайн жишиг, туршлагад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгон, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Төрийн алба зарсан “60 тэрбум”, иргэдийн боломжийг хулгайлсан “ЖДУ” улс төрчид, авлига, сонирхлын зөрчилд орооцолдож хууль зөрчсөн албан тушаалтнуудад нам харгалзахгүй хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Иргэн нь шийддэг нийгэм

- Хүний эрхийг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарчмыг шалгуур болгож Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжид бүхэлд нь дүн шинжилгээ, хяналт хийж хууль тогтоомжийг шинэчлэх арга хэмжээ авна.
- Иргэн нь төрийн удирдах албан тушаалтнаас “Иргэний асуулга асуух эрх”-ийг баталгаажуулах бие даасан хууль гаргана.
- Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгол хийх үүргийг хуульчлан баталгаажуулна.
- Парламентын хянан шалгах чиг үүргийг боловсронгуй болгож, УИХ-аас төлөөллөө хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтын тухай бие даасан хуультай болно.
- Иргэдээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчмыг нутгийн удирдлагад бэхжүүлэх, хотын засаглалыг сайжруулахад баримталж, орон нутгийн эрх мэдэл, төсвийн боломжуудыг нэмэгдүүлнэ.
- Гэмт хэрэгт холбогдон сонгогчдын итгэлийг алдсан УИХ-ын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.
- Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- Улс төрийн намыг санхүүгийн хувьд ил тод, хариуцлагатай, бодлогын байгууллага болгох шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, чөлөөт, олон ургалч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгааг дээшлүүлж, хэвлэл мэдээллийн багц хуулийг батлан гаргаж, эрүүгийн тогтолцоогоор дарамтлах байдлыг зогсоно.



- Иргэн нь иргэний бүртгэл, нийгмийн даатгал, эрүүл мэнд, татвар зэрэг төрийн үйлчилгээг нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж харгалзахгүйгээр авах журмыг тогтооно.

4.4. Хөгжлийг дэмждэг хууль

- Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хууль, дүрэм, журмыг тогтвортой, ойлгомжтой байх хууль зүйн цогц шинэчлэл хийнэ.
- Худалдаа, арилжааны харилцааг зохицуулсан бие даасан хууль батлан хэрэгжүүлнэ.
- Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, шаардлагатай шинэчлэлийг хийж, зохисгүй үр дагаварыг арилгах арга хэмжээ авна.
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодитоор хэрэгжүүлж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.
- Худалдаа, бизнесийн маргааныг үр ашигтай, шуурхай шийдвэрлэх шүүхийн бус тогтолцоог улам бэхжүүлж, шүүхэд өрсөлдөөн үүсгэнэ.
- Татвар, төрийн хяналт шалгалтыг (мэргэжлийн хяналт) иргэн, хуулийн этгээдэд зөвлөх, боломж олгох, дэмжих чиглэлээр шинэчлэн зохион байгуулна.
- Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ. Цахим өргөдөл, гомдлын 11-11 төвийн үйл ажиллагааг сэргээнэ.
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг зааглан, тогтолцоог шинэчилнэ.
- Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод болгоно.

40

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ



Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг туштай хэрэгжүүлнэ. Гадаад бодлогын үзэл баримтлалыг туштай үргэлжлүүлж, цаг үеийн нөхцөл байдалд зохицсон идэвхтэй байр суурийг баримталж, Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлнэ. Хоёр хөрштэйгөө нэн найрсаг, тэнцвэртэй харилцааг эрхэмлэж, гадаад харилцааг эдийн засагжуулахад идэвхтэй байр суурь баримтална.

Батлан хамгаалах салбарыг шинэчлэн чадавхжуулж, мэргэжлийн арми иргэний хамгаалалтын хосолмол бодлогыг хэрэгжүүлнэ. Орон нутгийн иргэдэд суурилсан хамгаалалтыг бэхжүүлэх, иргэний хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар салбарын хариуцлагагүй байдлыг арилгана. Уламжлалт бус аюултай тэмцэх бодлогыг шинээр боловсруулан, салбараас тэтгэврт гарсан иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарна.

5.1. Үндэсний аюулгүй байдал

- Улс орныхоо тусгаар тогтол, бүрэн эрхт байдлыг баталгаажуулна.
- Улс орны язгуур эрх ашигийг тэргүүнд эрэмбэлж, Үндсэн хууль, ардчилал, хүний эрх, хуулийн засаглалыг хамгаална.
- Нийт ард түмний сайн сайхан аюулгүй байдлын төлөө төр засгийн шийдвэр нь судалгаанд суурилах нь зайлшгүй шаардлага гэж үзнэ.
- Үндэсний эв нэгдэл, оюун санааны нэгдмэл байдал, үндэсний өв соёл, бахархлыг бодлогоор дэмжинэ. Өв соёл, эх түүх, хэл бичиг, соёлын дархлаа бүхий монгол бахархлыг дэмжих замаар үндэсний эв нэгдлийг сахин хамгаалах цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Соёлын биет бус өвийг үндэсний баялагт тооцож бүртгэлжүүлэн ЮНЕСКО-д бүртгүүлэх ажлыг эрчимжүүлж, ийм өвийг хөгжүүлэхийг дэмжин, гадагш алдагдахыг хязгаарлана.
- Улсын өрийн дарамтыг багасган, дотоодын хүнс, эрчим хүч, шатахуунаар өөрийгөө бүрэн хангаж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн бие даасан байдал, хямралд өртөхгүй байх чадавхийг бэхжүүлнэ. Хуурамч мэдээлэл, дижитал халдлагатай тэмцэх, төр, иргэнийхээ цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тусгай бодлого хэрэгжүүлнэ. Иргэдийнхээ тэнцвэртэй, бодитой мэдээлэл авах нөхцөл боломжийг дэмжинэ.
- Монголд байхгүй мэргэжлээс бусад чиглэлээр гаднаас ажиллах хүч авахыг хуулиар хориглоно.
- Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарч ажиллана.
- Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.

5.2. Гадаад бодлого

- Гадаад харилцааны бодлого нэгдмэл байж нэг цонхоор хэрэгжиш.
- Гуравдагч хөршүүдтэй харилцах хамтын ажиллагааг эдийн засагжуулах байр суурь баримтална.
- Бус нутгийн аюулгүй байдал, дэлхий нийтийн энх тайвныг сахин хамгаалахад Монгол Улс хувь нэмэр оруулахыг дэмжиж ажиллана.
- Монгол Улсын эрх ашигт нийцсэн эдийн засгийн ихээхэн үр ашигтай, сөрөг үр дагаваргүй, бус нутгийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- Хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааг эрчимжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ажиллах цагийг уртасган иргэд улсын хилээр саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан гадаадын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, импортоор орж ирэх техник технологи, ноу-hau зэрэгт хөнгөлөлт үзүүлэн, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь экспортод гаргах боломжийг бүрдүүлнэ
- Эдийн засгийн чөлөөт бусэд бизнес инкубатор төв байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.
- Дипломат албыг мэргэшсэн өндөр ёс суртахуунтай төлөвшүүлэхэд тусгайлан анхаарна.
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, ажлын байранд дүн шинжилгээ хийн, иргэддээ үйлчлэх, эдийн засгийн хамтын ажиллагаагаа түлхүү хөгжүүлэх чиглэлээр өөрчлөн зохион байгуулна.

5.3. Батлан хамгаалах бодлого

- Эх оронч үзлийг дэмжиж, цэргийн алба хаах хугацааны сургалтын агуулга хөтөлбөрийг сайжруулж, гамшигийн менежментийн сургалтыг зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдэд тусгай хөтөлбөр болгож оруулна.
- “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдсан оюутнуудыг төрийн албанад ороход нэмэлт оноо өгнө.
- Инженерийн цэргийн антиудыг чадавхжуулж, батлан хамгаалах, улсын онц чухал обьектуудын бүтээн байгуулалтад ажиллуулна.
- Цэрэг армийн хангалтын үйлдвэрлэлийг бий болгоно.
- Кибер халдлагатай тэмцэх, төр, иргэнийхээ цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тусгай бодлого хэрэгжүүлнэ.
- Байгалийн гамшиг, цар тахал, халдварт өвчнийг даван туулах, техник технологи, хүн хүч болон зохион байгуулалтын чадавхыг сайжруулж стратегийн нөөц бүрдүүлнэ.



42



- Хямралт нөхцөл байдлын үед нийслэл болон орон нутагт нэмэлтээр ажиллах цэргийн үүрэгтнүүд, иргэдийн сайн дурын жижиг булгуудийг сургаж, тоног төхөөрөмжөөр хангах бодлого баримтална.
- Уламжлалт бус аюул (цар тахал, кибер довтолгоо, хуурамч мэдээ, мэдээлэл г.м)-тай тэмцэх тухай хууль баталж, шинэ төрлийн аюулд хариу өгөх чадвартай бүтцийг бий болгоно.
- Батлан хамгаалах салбарт хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг хурдтай нэвтрүүлж тусгай нэгжийг шинээр байгуулна.
- Цэргийн нэгдсэн эмнэлэг, төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг орчин үеийн багаж төхөөрөмжөөр иж бүрэн тоноглож, тэргүүлэх зэргийн эмнэлэг болгож дайны болон гамшигийн үед дэлгэн ажиллах боломжтой явуулын болон хээрийн эмнэлгүүдийг буй болгоно.
- Батлан хамгаалах салбарт ажиллаж буй албан хаагчдын цол, цалин урамшууллыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- Цэргээс тэтгэвэрт гарсан албан хаагчид шинээр ажил эрхлэх, өөр мэргэжлээр суралцахыг урамшуулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Энхийг сахиулах ажиллагаанд үргэлжлүүлэн оролцож, бус нутгийн хэмжээний энхийг сахиулагчдыг сургах олон улсын төвийг нэмж байгуулан, батлан хамгаалахын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.4. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил

Экосистемийн тэнцвэртэй байдал


- Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулна.
- Төрөөс усны талаар баримтлах бодлогыг шинэчилж, уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар болон хот байгуулалтын бодлогыг тодорхойлоходоо усны нөөц, ашиглалтын бодлогод нийцүүлэх зарчмыг баримтална.
- Усны хэрэглээ, хяналт, хэмнэлтийн бодлогыг бий болгож, менежментийг сайжруулна.
- Улсын хэмжээнд байнгын сэлгэлттэй томоохон усан сан (усан цахилгаан станц), цогцолбор, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг хууримтуулах замаар.gov тал, хээрийн нутгаа усаар хангах чиглэлээр ажиллана.
- “Туулын усан сан цогцолбор” төслийг хэрэгжүүлнэ.
- “Саарал” усыг дахин ашиглах, түүнд олгох урамшууллын тогтолцоог бий болгоно.



- Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг улс даяар нэвтрүүлнэ.
- Цөлжилттэй тэмцэх шинэ технологийг нэвтрүүлж, энэ чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг сөрөг нөлөөллийг эртилрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
- Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.
- Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулна.
- Экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад үйл ажиллагаа болон өөрийн хөрөнгөөр хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх асуудлыг нэгдсэн, цогц бодлоготой болгож, бие даасан агентлагийг байгуулна.

Байгаль орчны тогтвортой хөгжил

- Газар ашиглалт, хот суурин, бус нутгийн төлөвлөлт, байгалийн нөөц ашиглах замаар эдийн засгийн өсөлтийг хангах бодлого, арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, биологийн төрөл зүйлийн орчныг дордуулахгүй байх шалгуур үзүүлэлтийг баримтлах тогтолцоог бий болгоно.
- Эрчим хүч, аж үйлдвэрийн салбар, гэр хорооллын нүүрсний хэрэглээг хамарсан Агаарын чанарын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Шахмал түлшний үйлдвэрийн стандартыг олон улсын түвшинд нийцүүлнэ.
- Боловсруулах үйлдвэрт гүний усны ашиглалтыг хязгаарлаж, гадаргын усны ашиглалтыг түлхүү дэмжинэ.
- Утааг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологийг ашиглан дулаан, цахилгаан нийлүүлэх иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Хөдөө, орон нутагт нам даралтын зуухнуудыг татан буулгаж, нэгдсэн системд холбоно.



- Аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд байгаль орчны хуулийг зөрчсөн аж ахуйн нэгжийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах, цаашид олгохгүй байх бодлого баримтална.
- Уул уурхайн нөхөн сэргээлт хийлгүй орхисон аж ахуй нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд оногдуулах хариуцлага, ял шийтгэлийг эрүүгийн хуулиар чангатгана.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх багийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж өөрөө сонгодог сонирхлын зөрчилтэй тогтолцоог өөрчилж, хуулийг боловсронгуй болгоно.
- Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан ногоон эдийн засагт сууринсан хөгжлийн үе шат руу шилжинэ.



“АРДЧИЛСАН НАМ” -Д

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1254
танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Ардчилсан нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам” -ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр /.....#..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ